

“Ажил мэргэжлийн уралдаан”

Хан-Уул Эрүүл Мэндийн Төв үүсгэн байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тохиолдуулан Эрүүл мэндийн төвийн эмч сувилагч нарын дунд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхэд багаар ажиллах ур чадварыг сайжруулах, болзошгүй гамшгийн эрсдэлийн үеийн бэлэн байдлыг хангаж ажиллах, эмч сувилагч нарын яаралтай тусламжийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилготой эмч сувилагч нарын дунд “Ажил мэргэжлийн уралдаан”-ыг 2025 оны 09 сарын 19-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Уралдаанд 6 хүний бүрэлдэхүүнтэй 5 баг оролцож, онолын мэдлэг, Blue code -багаар үзүүлэх ур чадвар, Олон улсын хөл хориот өвчний үеийн хариу арга хэмжээ авах, эмнэлзүйн тохиолдол дээр багаар ажиллах хэлбэрээр зохион байгуулж, эрчимт эмчилгээний эмч Долгорсүрэн ахлагчтай баг тэргүүн байранд шалгарууллаа.



